



БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН АЛБАН ДААЛГАВАР

2016 оны 03 сарын 29 өдөр

Дугаар 01

Өлгий

Ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх,  
хамгаалах тухай

Улсын хэмжээнд 2016 онд 16 аймгийн 114 сумын 354 удаагийн ой, хээрийн гал түймэр гарч 45.645 га ой, 6.602.563 га хээр нийт 6.6 сая га талбай шатсан байна.

Ой, хээрийн гал түймрийн улмаас ард иргэд, аж ахуйн нэгжийн өмч хөрөнгөд 3.3 тэрбум төгрөг, байгаль, экологид 59.4 тэрбум төгрөг, нийт 62.7 тэрбум төгрөгийн хохирол учирч, түймрийг унтраахад 517.9 сая төгрөгийн зардал гарсан байна.

Манай орны нийт нутгаар 2015-2016 оны өвлийн улиралд цас их орж зарим нутгаар өвөлжилт хүндэрсэн боловч хаврын хуурайшилтын улирал эхэлж цасан бүрхүүл хайлсны улмаас ой, хээрийн гал түймрийн эрсдэл нэмэгдэж өнөөдрийн байдлаар Дорнод, Булган, аймгийн нутагт нийт 3 удаагийн ой, хээрийн гал түймэр гараад байна.

Иймд Улсын Онцгой комиссын "Ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх зарим арга хэмжээний тухай" 01 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийг хангуулахтай холбогдуулан "Ой, хээрийн гал түймэртэй тэмцэх" ажлыг эрчимжүүлэх зорилгоор дараах АЛБАН ДААЛГАВРЫГ хүргүүлж байна.

Нэг. Сумдын Засаг дарга, Онцгой комиссын дарга нарт ДААЛГАХ нь:

1. Гамшгаас хамгаалах тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.3 дугаар зүйлд заасны дагуу аймаг, орон нутаг, сум, дүүрэг, баг хороо, төрийн болон төрийн бус байгууллага, ойн мэргэжлийн анги, ойн санг гэрээгээр эзэмшигч нөхөрлөлийн ой, хээрийн гал түймэртэй тэмцэх бэлэн байдлын төлөвлөгөө гаргаж ажиллах.

2. Ой хээрийн түймэр унтраах үйл ажиллагаанд дайчлагдан ажиллах иргэдийн тоо, автомашин, техник, багаж хэрэгслийн судалгааг гаргах, нөөцийг бүрдүүлэх, техникийн найдвартай ажиллагааг хангах.

3. Ой, хээрийн гал түймрийн эрсдэл өндөртэй сумдад гарсан ой, хээрийн түймрийг богино хугацаанд илрүүлэх, унтраах, зорилгоор хяналтын цэг /пост/ байгуулж, төрийн захиргааны байгууллагатай хамтран хөдөлгөөнт болон морин эргүүлийг тогтмол зохион байгуулж, үүрэг гүйцэтгэх бие бүрэлдэхүүнийг томилгоожуулж, шаардлагатай эд материалаар хангах.

4. Сумын хилийн зааг дээр гарсан ой, хээрийн гал түймрийг нутаг дэвсгэрийн харьяалал харгалзахгүй унтраах, гал түймрийн нөхцөл байдал хүндэрсэн үед хамтран ажиллах ажлыг шуурхай зохион байгуулах.

5. Ой, хээрийн гал түймрийн голомтод ажиллах бие бүрэлдэхүүнийг байршил тодорхойлогч /GPS/, сансрын холбооны хэрэгслээр /IRIDIUM/ бүрэн хангах, түймрийн голомтын уртраг, өргөрөгийн солбилцлыг шуурхай тодорхойлох, гал түймрийн дуудлагыг хүлээн авсан албан тушаалтан болон /оператор/ цагийн байдал, авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар Онцгой байдлын газар, Цагдаагийн байгууллагад цаг алдалгүй шуурхай мэдээлж байх.

6. Ой, хээрийн түймэр гарсан тухай бүр Цагдаагийн байгууллагад мэдээлж, гарсан шалтгаан нөхцөл, эзэн холбогдогчийг илрүүлэх, тогтоох ажилд шаардлагатай мэдээ мэдээлэл солилцон хамтран ажиллах.

7. Цаг агаарын хуурайшилтын "нэн аюултай", "аюултай" зэрэгт хүрсэн үед ногоон бүсэд зорчих ард иргэд, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хязгаарлах, галын аюулгүй байдлыг хангуулахад орон нутгийн байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, Цагдаагийн байгууллага, Онцгой байдлын газар, Ус, цаг уур, орчны шинжилгээний алба болон холбогдох бусад байгууллагуудтай хамтран ажиллах, хяналт тавих.

8. Хуурайшилттай үедой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх тухай сэрэмжлүүлгийг орон нутгийн радио телевиз, хэвлэл мэдээллийн хэрэгслээр гаргах, уулзалт ярилцлага зохиох, зурагт хуудас, санамж бичиг хэвлүүлэн тараах, ой мод руу орох гол зам, овоо харуулын байрны дэргэд зорчих газар харагдахуйц өндөрлөг газруудад гал түймрээс урьдчилан сэргийлэх анхааруулсан замын тэмдэг, самбар байрлуулах зэргээр сурталчилгааны ажлыг зохион байгуулах.

Хоёр: Аймгийн Онцгой комиссын гишүүн, Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга /Ш.Марат/, Улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны дарга /С.Медеухан/ нарт ДААЛГАХ нь

1. Ойн сан бүхий газартай хиллэж байгаа хөдөө аж ахуйн болон бусад ангиллын газруудаар ой, хээрийн гал түймрээс хамгаалах хамгаалалтын шороон зурвас байгуулах, сэргээх ажлыг эрчимжүүлэх, энэ чиглэлээр сум, багийн Засаг дарга нартай хамтран ажиллах.

2. Хэт их хуурайшилттай улиралд ойгоос мод бэлтгэх, ойн дагалдах нөөц, ашиглах аялал зугаалгыг хязгаарлах тухайн сум, багийн Засаг дарга, ойн анги, байгаль орчны улсын байцаагч, байгаль хамгаалагч нарыг нутаг дэвсгэрийн хэмжээнд ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах хөдөлгөөнт эргүүл, хяналтын цэг ажиллуулах талаар хамтран ажиллах.

3. Ойн тухай хуулиар хүлээсэн чиг үүргийн дагуу албан газар, аж ахуйн нэгж байгууллагууд, нөхөрлөлийн гишүүд, иргэдэд ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах талаар ухуулга, сургалт, сурталчилгааг зохион байгуулж явуулах.

4. Сумдын байгаль орчны улсын байцаагч, байгаль хамгаалагч, ойн ангийн бие бүрэлдэхүүнийг хариуцсан нутаг дэвсгэртээ хяналтаа сайжруулах, эргүүл, хяналт шалгалтын ажлаа эрчимжүүлэх талаар үүрэг чиглэл өгч ажиллах.

5. Тусгай хамгаалалттай газрыг ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах тодорхой ажлыг зохион байгуулах.

6. Ойн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон төрийн бус байгууллага, иргэд, ойн санг гэрээгээр эзэмшигч нөхөрлөл, аж ахуйн нэгжийн багаж техник, гар багаж хэрэгслийн нөөцийг бүрдүүлэх, судалгааг гарган гал түймэр унтраах дадлага сургалтыг аймгийн Онцгой байдлын газартай хамтран зохион байгуулах.

Гурав: Аймгийн Онцгой комиссын гишүүн, Цагдаагийн газрын дарга, /цагдаагийн хурандаа М.Батболд/-д ДААЛГАХ нь:

1. Ой, хээрийн гал түймрийн шалтгаан нөхцөлийг хуулийн хугацаанд шалган тогтоож, эзэн холбогдогчдод хариуцлага хүлээлгэх, авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар аймгийн Засаг дарга, Онцгой комиссын дарга, олон нийтэд мэдээлэх.

2. Аймгийн хэмжээнд цаг агаарын хуурайшилтын аюултай, нэн аюултай зэрэгт хүрсэн үед сумдын цагдаагийн бүрэлдэхүүн хариуцсан сумын байгаль орчны улсын байцаагч, байгаль хамгаалагч нартай хамтран цагдаагийн эргүүл, хяналтын цэгийг байгуулах үүрэг чиглэлээр хангаж, тодорхой ажил зохион байгуулж ажиллах.

3. Ой, хээрийн гал түймрийн үед эрүүгийн байцаан шийтгэх үйл ажиллагаа буюу хэргийн газар үзлэг хийх, гал түймэр гарсан тухай акт, шинжээчийн дүгнэлт гаргах, мөрдөн шалгах, гал түймрийн шалтгаан нөхцөл, эзэн холбогдогчийг тогтоох ажлыг шуурхай зохион байгуулах.

4. Цаг агаарын хуурайшилтын "нэн аюултай", "аюултай" зэрэгт хүрсэн үед эргүүл хяналтын цэгийг Онцгой байдлын газартай хамтран зохион байгуулан ажиллуулж, ногоон бүсэд зорчих иргэд болон тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хязгаарлах, техникийн галын аюулгүй байдлыг хангуулахад хяналт тавих.

Дөрөв: Хилийн цэргийн 0165 дугаар ангийн захирагч /хурандаа Б.Мөнхбат/, 0285 дугаар ангийн захирагч /хурандаа Ш.Баатарсүх/ нарт ДААЛГАХ нь:

1. Ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах арга ажиллагаанд хил хамгаалах анги, заставт үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчдыг сургаж, бэлтгэх, холбогдох хууль тогтоомж, тогтоол шийдвэр, албан даалгаврыг сурталчлах ажлыг зохион байгуулах.

2. Ой, хээрийн гал түймрийн үед албан хаагчдыг түймэр унтраах ажилд татан оролцуулах, бие бүрэлдэхүүнийг шаардлагатай техник хэрэгслээр хангах.

Тав: Аймгийн Онцгой комиссын орлогч дарга, Онцгой байдлын газрын дарга, /онцгой байдлын хурандаа Ц.Баттулга/-д ДААЛГАХ нь:

1. Аймгийн Онцгой комиссын хурлаар Ойн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1, 18.1.8, 18.2.10, 18.2.14, 18.15 дахь заалтыг үндэслэн ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх асуудлыг хэлэлцүүлэн төлөвлөгөө гарган батлуулж шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлэх.

2. Ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээнд иргэдийг сургах, холбогдох хууль тогтоомж, тогтоол шийдвэр, албан даалгаврыг сурталчлах ой, хээрийн гал түймрийг унтраах мэргэшсэн баг зохион байгуулж тэдний сургалт бэлтгэлийг хангах, ой, хээрийн гал түймэр гарсан үед унтраах ажлыг шуурхай зохион байгуулж ажиллах.

3. Онцгой байдлын газрын бие бүрэлдэхүүний ой, хээрийн гал түймрийг унтраах техник, тоног төхөөрөмжийн бэлтгэл бэлэн байдлыг хангуулах.

4. Ой, хээрийн гал түймрийн үед гамшгаас хамгаалах албад, тусгай төрөл мэргэжлийн ангийг удирдлагаар хангаж, шаардлагатай тохиолдолд Засгийн газрын 2011 оны 340 дүгээр тогтоолын 1,2 дугаар хавсралтыг хэрэгжүүлж ажиллах.

5. Ой, хээрийн гал түймэр унтраах үйл ажиллагаанд 24 цагаас доошгүй хугацаанд амарсан бэлтгэл ээлжийн алба хаагчийг томилгоожуулах, зайлшгүй тохиолдолд алба хаагчдыг 5 цагаас доошгүй хугацаанд амраах.

6. Ой, хээрийн гал түймрийн дуудлагаар явах үед автомашинд шатахуун тээвэрлэх шаардлагатай бол зориулалтын саванд хийж, цохилт, доргилтын үед шатахууны сав цоорохгүй байхаар жийргэвч, хамгаалалт хийж, гал түймрийн голомтонд үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчид үлээгч аппарат болон бусад техникт шаардлагатай шатах, тослох материалыг биедээ авч явахыг бүрэн хориглож, хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны дүрмийг чандлан сахих.

7. Ой, хээрийн гал түймрийн голомтонд ажиллах 1 бүлгийг 12 хүний бүрэлдэхүүнтэй томилж, офицероор ахлуулан, байршил тодорхойлогч /GPS/, сансарын холбооны хэрэгслээр /IRIDIUM/ болон байр зүйн зургаар хангах, цаг агаарын нөхцөл байдал, түймрийн голомтын га талбай, солбилцолыг найдвартай, шуурхай тодорхойлж мэдээлэх.

8. Орон нутгийн телевиз, радио, олон нийтийн мэдээллийн хэрэгслийг ашиглан хавар, намрын хуурайшилтын улиралд иргэд, олон нийтэд ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, унтраах чиглээр сэрэмжлүүлэг, ухуулга, сурталчилгаа нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах.

Албан даалгаврын биелэлтийг хангах ажлын хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээ, тайланг 06 дугаар сарын 10, 11 дүгээр сарын 10-ны дотор Онцгой байдлын газарт ирүүлж, ажлын чанар, үр дүнг нэгтгэн дүгнэж аймгийн Онцгой комиссын даргад танилцуулахыг /онцгой байдлын хурандаа Ц.Баттулга/-д үүрэг болгосугай.

ОРЛОГЧ



Н.САНАТБЕК